

Хэвлэлийн мэдээ

№.15-11

2015 оны 7 дугаар сарын 3-ны өдөр

7 дугаар сарын 4-ний өдөр (Бямба гараг), Улаанбаатар хотын Үндэсний соёл амралтын хүрээлэнд “Японы поп соёлын өдөрлөг”-ийг тус яамны зүгээс зохион байгуулах гэж байна.

Уг арга хэмжээг Монголын хүүхэд залуусын сонирхдог Японы анимэ, манга, косплэй зэргийн фэнүүдийн нэгдэл болох Монгол дахь Японы соёлыг сонирхогчдын холбоотой хамтран зохион байгуулж байгаа бөгөөд, косплэй, дууны тэмцээн, кэндо ба каратэгийн үзүүлбэр гэх мэт төрөл бүрийн тайзны хөтөлбөрүүдээс гадна олон сонирхолтой булангуудыг ажиллуулахаар бэлтгээд байна. Түүнчлэн өнгөрсөн жил Японд зохион байгуулагдсан “Найм дахь удаагийн манга шагнал” уралдааны гранпри шагналт, манга зураач Н.Эрдэнэбаяр болон Мисс Visit Japan Аялал жуулчлалын элч А.Баярцэцэг (“Miss International 2014”-д Монгол улсыг төлөөлөн оролцсон) нар уг өдөрлөгт зочноор хүрэлцэн ирж оролцох ба Япон улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Аялал жуулчлалын газар болон H.I.S компани Японы аялал жуулчлалыг танилцуулах буланг нээн ажиллуулна.

Энэхүү арга хэмжээгээр дамжуулан Монголчуудад “Cool Japan” буюу Япон орны гайхалтай талуудыг илүү таниулж чадна гэж найдаж байна.

Хэзээ: 2015 оны 7 дугаар сарын 4-ний өдөр (Бямба гараг)

Хаана: Улаанбаатар хот, Үндэсний соёл амралтын хүрээлэн (Хүүхдийн парк)

Агуулга:

- Тайзны хөтөлбөр (Анимэ дууны тэмцээн, косплэй тэмцээн, кэндо болон каратэгийн үзүүлбэр, хөгжөөнт тэмцээнүүд, мэйд-батлер үзүүлбэр гэх мэт)
- Булан (Мэйд кафе, анимэ-манга, J-POP, поп соёл, Японы соёл, зураг авахуулах булан, Японы Аялал жуулчлалын газрын булан гэх мэт)

Сурвалжлага авах: чөлөөтэй

Лавлах:

Монгол улсаас Япон улсад суугаа Элчин сайдын яам

Соёл, мэдээллийн хэлтэс

(Э.Болортуяа)

Embassy of Japan in MONGOLIA

Утас: 11-320777